



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН СТРАТЕГИ

Санхүүгийн бодлогын газрын
Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Сүх-Очир

АГУУЛГА



- “ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР”-ИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
- “ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР”-Д НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС
- ӨРИЙН УДИРДЛАГЫН 2016-2018 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
- ӨРИЙН УДИРДЛАГЫН 2019-2022 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ

“ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР”-ИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

(тэрбум төгрөг)

№	ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2015.12.31	2016.12.31	2017.12.31	2018.12.31	2019.06.30
1	Засгийн газрын дотоод өр	3,333.2	5,488.8	3,461.9	1,564.7	1,485.8
2	Засгийн газрын гадаад өр	7,881.2	12,363.8	16,857.8	18,865.6	19,289.2
3	Засгийн газрын өрийн баталгаа	2,743.5	3,451.5	1,663.7	1,130.7	1,104.3
4	Барих-шилжүүлэх нөхцөлтэй концесс	261.0	668.9	768.2	806.0	806.0
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР		14,163.7	22,280.1	22,751.6	22,367.0	22,685.3
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		12,124.2	18,861.0	20,212.1	18,955.9	19,561.4
ӨРИЙН ХЯЗГААР		58.3%	88.0%	85.0%	80.0%	75.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ		52.4%	78.8%	72.5%	58.9%	54.4%
Засгийн газрын өр/ДНБ		61.2%	93.1%	81.6%	69.5%	63.1%

“ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР”-Д НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС



ӨРИЙН УДИРДЛАГЫН 2016-2018 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

Стратегийн шалгуур үзүүлэлт	Үзүүлэлт	2016	2017	2018
Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа	Хүрэх үр дүн	12.0%	10.5%	8.0%
	Гүйцэтгэл	22.9%	12.4%	4.9%
Засгийн газрын өрийн үлдэгдлийн цэвэр өөрчлөлтийг ДНБ-д харьцуулсан харьцаа	Хүрэх үр дүн	2.5%	2.2%	1.0%
	Гүйцэтгэл	32.8%	1.7%	-1.2%
Засгийн газрын нийт өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацаа	Хүрэх үр дүн	7.0 жил	7.2 жил	7.5 жил
	Гүйцэтгэл	6.0 жил	7.6 жил	8.2 жил
ЗГ-ын дотоод ҮЦ-г барьцаалж гаргах өрийн баталгааны үлдэгдлийн хэмжээ	Хүрэх үр дүн	1.0 их наяд төгрөгөөс хэтрэхгүй		
	Гүйцэтгэл	₮993.1 тэрбум		

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2019-2022 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ

ЗОРИЛТ 1.

Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

ЗОРИЛТ 2.

Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталж, тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна.



Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд хамгийн бага зардлаар санхүүжүүлэхэд чиглэнэ.

ЗОРИЛТ 3.

Орчин үеийн технологийн дэвшлийг ашигласан Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэд бүтцийг бүрдүүлнэ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, зах зээлийн нээлттэй, өрсөлдөөнт, хүртээмжтэй байдлыг хангаж, Засгийн газрын үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулна.

ЗОРИЛТ 4.


Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.

ЗОРИЛТ 5.


Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх.

ИРЭХ ОНУУДАД ТӨЛӨГДӨХ ТОМООХОН ТӨЛБӨРҮҮД


- 2021 онд төлөгдөх
“Мазаалай бонд”
500 сая ам.доллар, 10.875 хувийн хүүтэй
- 2022 онд төлөгдөх
“Чингис бонд”
1,000 сая ам.доллар, 5.125 хувийн хүүтэй
- 2023 онд төлөгдөх
“Гэрэгэ бонд”
800 сая ам.доллар, 5.625 хувийн хүүтэй
- 2024 онд төлөгдөх
“Хуралдай бонд”
600 сая ам.доллар, 8.750 хувийн хүүтэй



ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТӨЛБӨРИЙН НЭГДСЭН ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ



“ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР”-ИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ДАРАМТ



Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийг оновчтой хэрэгжүүлснээр Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2022 онд 39.1 хувьд хүрнэ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Засгийн газрын өрийн хязгаар, Засгийн газрын өрийн хамрах хүрээг тооцов.

ӨРИЙН УДИРДЛАГЫН БОЛОМЖИТ ХУВИЛБАРУУД

Загварчлал-1.

Засгийн газрын гадаад үнэт цаасыг гадаад валютын албан нөөцөд дарамт учруулахгүйгээр дахин санхүүжүүлэх

Мазаалай, Чингис бондуудын төлбөрүүдийн тодорхой хэсгийг дахин санхүүжүүлэх

Загварчлал-2.

Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт

ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд орж ирэх санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрийг ашиглах болон төслийн зээлийн ашиглалтыг хязгаарлах

Загварчлал-3.

Нэгдсэн төсвийн алдагдлыг бууруулах

Нэгдсэн төсвийн алдагдлыг бууруулах хувилбарууд

Загварчлал-4.

Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны зохистой хэмжээ

Төсвийн алдагдлын тодорхой хэсгийг дотоод үнэт цаасаар санхүүжүүлэх хувилбарууд

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ЗАРДАЛ, ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ


(2018 оны 12 сарын 31-ны байдлаар)

Эрсдэлийн үзүүлэлт		Гадаад зээл	Дотоод зээл	Нийт
Засгийн газрын өр (тэрбум төгрөг)		19,990.8	1,564.7	21,555.4
Засгийн газрын өр (сая ам.доллар)		7,563.9	592.0	8,155.9
ДНБ-нд эзлэх ЗГ-ын өр нэрлэсэн дүнгээр		62.1	4.9	67.0
ДНБ-нд эзлэх ЗГ-ын өр өнөөгийн үнэ цэнээр		51.8	4.9	56.6
Өрийн багцын зардал	Хүүгийн төлбөрийн ДНБ-нд эзлэх хувь	2.3	0.6	2.9
	Жигнэсэн дундаж хүү (хувь)	3.6	12.2	4.3
Дахин санхүүжилтийн эрсдэл	АТМ (жил) эргэн төлөгдөх дундаж хугацаа	8.4	5.0	8.2
	Богино хугацаанд төлөгдөх өр (нийт өрд эзлэх хувь)	2.2	10.6	2.7
	Богино хугацаанд төлөгдөх өр (ДНБ-нд эзлэх хувь)	1.7	0.5	2.2
Хүүгийн түвшний эрсдэл	АТР (жил) хүү шинэчлэгдэх дундаж хугацаа	7.7	5.0	7.6
	1 жилд тогтмолжуулах өр (нийт өрд эзлэх хувь)	13.0	10.6	12.8
	Тогтмол хүүтэй зээл ба бонд (нийт өрд эзлэх хувь)	88.3	100.0	89.0
Ханшийн эрсдэл	Гадаад валютаарх өр (нийт өрд эзлэх хувь)			92.7
	Валютын нөөцөд эзлэх богино хугацаат гадаад өр			5.9


Энэхүү тооцоололд Засгийн газрын өрийн баталгаа болон Барих-шилжүүлэх концессын багцын мэдээллийг хамруулаагүй болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛӨЛ


Гадаад
валютаар
илэрхийлсэн
өр /нийт өрд
эзлэх хувь/




Эргэн
төлөгдөх
дундаж
хугацаа
/жил/
ATM



Жигнэсэн
дундаж хүү
/хувь/



Хүү
шинэчлэгдэх
дундаж
хугацаа
/жил/
ATR



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2019-2022 ОНЫ СТРАТЕГИЙН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

- Төсвийн сахилга бат, санхүү мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах бодлогыг тууштай үргэлжлүүлэх замаар төсвийн алдагдал болон шинээр зээллэг үүсгэх хэрэгцээг бууруулна;
- Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийж, гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлж барагдуулах, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авна;
- Дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаас гаргахаас татгалзана. Өрийн дахин санхүүжилтэд урт хугацаанд жигд төлөгдөх эх үүсвэрийг ашиглахыг эрмэлзэнэ;
- Шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналд дүн, шинжилгээ хийх механизмыг бий болгож, эдийн засаг, нийгэмд зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан систем нэвтрүүлнэ;
- Олон улсын санхүүгийн байгууллагуудаас санал болгож байгаа болзошгүй эрсдэлээс сэргийлэх зээлийн шугамыг ашиглах механизмыг нэвтрүүлнэ;
- Барих-шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулах, өрийн бичиг бичих зэрэг өрийн хэрэгслээр өр үүсгэхгүй байх бодлогыг баримтална.

ДҮГНЭЛТ

- Улсын өрийн удирдлага, Засгийн газрын өрийн удирдлагын үйл ажиллагааг илүү мэргэжлийн түвшинд зохион байгуулах;
- Засгийн газрын өрийн стратегийн ач холбогдол, давуу талыг шийдвэр гаргагчдад ойлгуулах, дагаж мөрдөж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Зардал, эрсдэлийн шинжилгээг тогтмол хийж, үр дүнг шийдвэр гаргахад хэрэглэж хэвших;
- Засгийн газрын өрийн хамрах хүрээг оновчтой тодорхойлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг тооцоолох;



САНГИЙН ЯАМ

**АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА**